



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/273

Хэрлэн сум

**Хэвтрийн хүнд үйлчлүүлэгчид
асаргаа, сувилагаа хийхэд дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэвтрийн хүнд үйлчлүүлэгчид асаргаа, сувилагаа хийхэд Ач манал өрхийн Эрүүл мэндийн төвд 1,550,000 (нэг сая таван зуун тавин мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ